



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/703

Ховд

Мотоциклийн хөдөлгөөнийг түр
хугацаагаар хориглох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а”, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зам хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдал, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, учирч болох хор хохирол, эрсдлийг багасгах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал мотоцикльтой замын хөдөлгөөнд оролцохыг түр хугацаагаар хориглосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгуулах, ард иргэдэд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай анхааруулга, сэрэмжлүүлэг өгч, сурталчилах ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай хүргэж зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /Д.Мөнхболд/-т даалгасугай.

3. Захирамжид тусгагдсан арга хэмжээний үр дүн, явц, цаашид авах арга хэмжээний саналыг аймгийн Засаг даргад танилцуулж байхыг аймгийн Цагдаагийн газар /Д.Мөнхболд/, Замын цагдаагийн тасаг /Н.Балжинням/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ